



СОЁМБО ПРИНТИНГ ХХК -Д

**МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
НОМЫН САН**

Чингисийн өргөн чөлөө 4, 1 дүгээр хороо,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14240
Утас: 31 16 80, Цахим шуудан: director@nationallibrary.mn,
Цахим хуудас: www.nationallibrary.mn

2023.12.18 № 282
танай _____-ны № _____-т

**Гүйцэтгэгч сонгох ажиллагааг
түр түдгэлзүүлэх тухай**

Манай байгууллагаас зарласан МУУНС/202311004 дугаартай "Үндэсний номын сангаас эрхлэн гаргах номуудын хэвлэх ажлыг гүйцэтгэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах" тендер шалгаруулалтад оролцсон "Соёмбо Принтинг" ХХК-аас Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид "хууль" гэх)-ийн 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргасан байна.

Хуулийн 55 дугаар зүйлийн 55.4 дэх хэсэг, Сангийн сайдын 2019 оны 131 дүгээр тушаалаар батлагдсан "Тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журам" (цаашид "журам" гэх)-ын 4.6 дахь заалтыг тус тус үндэслэн захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилтийг 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн түр түдгэлзүүлсэн болохыг мэдэгдэж байна.

Хувийг: Адмон Принт ХХК-д

ЗАХИРАЛ



Б. ИЧИНХОРЛОО